

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хан-Уул Агро ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/037/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugss@gmail.com
	Б энд С аудит ХХК-ийн Захирал Д.Заяажаргал Утас: 99050268 Цахим хаяг: info@bcauditllc.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/307
танай _____-ны № _____-т

ХАН-УУЛ АГРО ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ц.ЦОГТСАЙХАН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хан-уул агро ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар шатахуун, автомашины граж түрээс, давс зэргийг 980,200.0 мянган төгрөг, харьцуулалтын аргаар цас хайлуулах бодис 67,200.0 мянган төгрөгөөр тус тус худалдан авсан байна.

Аудитын гол асуудал

Нийслэлийн өмчийн харилцааны газрын зөвшөөрөлгүйгээр тайлант онд 750.0 мянган төгрөгийн ном болон биет бус хөрөнгийг байгууллагын даргын А/46 тоот тушаалаар акталж данс бүртгэлээс хассан байна.

Бусад асуудал

Хан-уул агро ОНӨААТҮГ нь ерөнхий нягтлан бодогчгүй бөгөөд удирдлага менежмент, төсөв санхүүгийн сахилга батыг сайжруулан тогтвор суурьшилтай мэргэжлийн дадлага туршлагатай мэргэшсэн нягтлан бодогч авч ажиллуулах шаардлагатай.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АУОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон****/төгрөгөөр/**

Мөрийн дугаар	Балансын үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	372,017.92	526,408,392.86
1.1.2	Авлага	5,950,000.00	6,163,186.00
1.1.6	Бараа материал	27,214,905.00	173,571,663.00
1.1.11	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33,536,922.92	706,143,241.86
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,567,838,897.32	1,428,526,373.18
1.2.10	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,567,838,897.32	1,428,526,373.18
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,601,375,820.24	2,134,669,615.04
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1.3	Татварын өр	132,878,500.00	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,405,347,916.55	1,171,895,030.12
2.1.1.13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,538,226,416.55	1,171,895,030.12
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.2	ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,538,226,416.55	1,171,895,030.12
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.1	Төрийн өмч	419,731,271.00	419,731,271.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(356,581,867.31)	543,043,313.92
	Тайлант үеийн ашиг		899,625,181.23
	Өмнөх үеийн ашиг		(356,581,867.31)
2.3.11	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	63,149,403.69	962,774,584.92
24	ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,601,375,820.24	2,134,669,615.04

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон****/төгрөгөөр/**

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,359,060,141.78	7,676,211,174.63
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	2,359,060,141.78	7,676,211,174.63
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,494,055,478.27	6,776,535,993.40
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(134,995,336.49)	899,675,181.23
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(134,995,336.49)	899,675,181.23
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(134,995,336.49)	899,675,181.23
23.3	Бусад олз (гарз)	9,927,875.05	50,000.00
24	Орлогын нийт дүн	(144,923,211.54)	899,625,181.23
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	419,731,271.00			(211,658,655.77)	208,072,615.23
2	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(144,923,211.54)	(144,923,211.54)
3	Өмчид гарсан өөрчлөлт					
4	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	419,731,271.00			(356,581,867.31)	63,149,403.69
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
6	Залруулсан үлдэгдэл					
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				899,625,181.23	899,625,181.23
9	Өмчид гарсан өөрчлөлт					
10	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	419,731,271.00			543,043,313.92	962,774,584.92

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,272,896,350.00	7,371,562,048.11
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	332,896,350.00	97,747,518.11
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,940,000,000.00	7,273,814,530.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,310,344,642.73	6,794,543,893.17
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,071,091,121.00	3,588,434,922.09
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	152,940,359.63	456,484,601.74
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	69,235,194.59	814,085,602.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	104,856,906.98	208,093,901.25
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	651,374,619.68	830,666,376.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	8,842,871.96	133,494,500.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	5,670,637.38	9,977,776.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	246,332,931.51	753,306,214.09
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(37,448,292.73)	577,018,154.94
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	59,500,000.00	50,981,780.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	59,500,000.00	50,981,780.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(59,500,000.00)	(50,981,780.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(96,948,292.73)	526,036,374.94
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	97,320,310.65	372,017.92
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	372,017.92	526,408,392.86

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон. /мянган төгрөгөөр/**

Үзүүлэлт		2024			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орлого	Үндсэн үйл ажиллагааны орлого	7,275,000.0	7,578,463.7	(303,463.7)	95.9
	Бусад орлого	50,000.0	97,747.5	47,747.5	51.2
	Нийт орлого	7,325,000.0	7,676,211.2	46,562.0	95.4
Зардал	Үндсэн болон нэмэгдэл цалин	3,596,000.0	3,594,384.9	(1,615.1)	100.0
	НД, ЭМДШимтгэлийн зардал	485,460.0	456,484.6	(28,975.4)	106.3
	Шатахууны зардал	800,000.0	798,131.3	(1,868.7)	100.2
	Сэлбэг хэрэгсэл	150,000.0	139,133.7	(10,866.3)	107.8
	Тос, тослох материалын зардал	35,000.0	31,542.0	(3,458.0)	111.0
	Байрны түрээс ашиглалт	210,000.0	208,093.9	(1,906.1)	100.9
	Тээврийн хэрэгслийн оношлогоо, татварын зардал	3,600.0	3,584.9	(15.1)	100.4
	Тээврийн зардал	6,500.0	6,063.9	(436.1)	107.2
	Машин, техник түрээсийн зардал	288,000.0	287,654.3	(345.7)	100.1
	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	248,000.0	247,759.6	(240.4)	100.1
	Сургалтын зардал	3,000.0		(3,000.0)	
	Үндсэн хөрөнгө худалдан авах зардал	51,000.0	50,981.8	(18.2)	100.0
	Хангамжийн материалын зардал	168,000.0	167,991.4	(8.6)	100.0
	Хөдөлмөр хамгааллын зардал	184,000.0	182,558.7	(1,441.3)	100.8
	Бараа материал	46,000.0	45,857.0	(143.0)	100.3
	Давс, бодис	196,000.0	195,202.0	(798.0)	100.4
	Ашиглалтын зардал	14,000.0	13,086.4	(913.6)	107.0
	Бичиг хэргийн зардал	7,000.0	6,785.5	(214.5)	103.2
	Аудит	10,000.0	10,000.0		100.0
	ААНОАТ, татварын байгууллагад төлсөн	620.0	616.0	(4.0)	100.6
	Даатгалын төлбөрт төлсөн	10,000.0	9,977.8	(22.2)	100.2
	Томилолтын зардал	10,000.0	9,247.0	(753.0)	108.1
	Шагнал урамшуулал, тэтгэмж тусламж	37,000.0	36,900.0	(100.0)	100.3
	Элэгдлийн зардал	262,000.0	261,440.3	(559.7)	100.2
	Бусад зардал	20,000.0	19,222.2	(777.8)	104.0
	Нийт зардал	6,841,180.0	6,776,536.0	(65,644.0)	100.9
		Ашиг, алдагдал		899,625.2	58,480.8

Гурав. Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 88,309.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 3,226.2 мянган төгрөгийн төлбөрийн 3 акт тогтоож, 39,394.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 45,688.2 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Аж ахуйн нэгж болон иргэнээс худалдан авсан урсгал зардал, оффисын түрээсийн төлбөрт И-баримт шивүүлээгүй байна.	1	45,688.2					1	45,688.2				
Туул голын хөвөөнд хогтой цас асгаж торгууль тавиулсаныг байгууллага ас төлсөн	1	1,000.0	1	1,000.0								
Түр тушаалтай ажилтан болон ТУЗ-ын нарийн бичигт тэтгэмж олгосо	1	600.0	1	600.0								
Тус байгууллагад А95, А98 хэргэлдэг авто машин байхгүй байхад 1.6 сая төгрөгийн шатахуун авч шууд зардалд бичсэн, анхан шатны дэмжин нотлох баримт	1	1,626.2	1	1,626.2								

байхгүй, жолоочын шатахууны тооцоо бодоогүй												
Өндөр үнэтэй сэлбэг материал олгохдоо техник комиссын акт гаргадаггүй, машин механизмын техникийн паспортонд бичилт хийдэггүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	1	39,394.6							1	39,394.6		
Дүн	5	88,309.0	3	3,226.2			1	45,688.2	1	39,394.6		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар илэрсэн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 221,331.7 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага, 12,997.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага хүргүүлсэн

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш 221.3 сая төгрөгийн зарлагын 19 гүйлгээг шилэн дансанд хугацаа хоцроож мэдээлсэн, зөрчил давтан гарсан байна.	1	221,331.7								1	221,331.7
Шинэ жил, санхүүчдийн баярын такс байгууллагаас төлж үргүй зардал гаргасан.	1	3,750.0	1	3,750.0							

ТУЗ-ын дарга өөртөө тогтоол гарган Канад улсруу томилолтоор явж 9,247.0 мянган төгрөгийн зардал гаргасан.	1	9,247.0			1	9,247.0				
Дүн	3	234,328.7	1	3,750.0	1	9,247.0			1	221,331.7